

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Төсвийн тухай хууль нь төсвийг төлөвлөх, боловсруулах, батлах, гүйцэтгэлийг тайлагнах, хянах зэрэг үндсэн харилцааг зохицуулдаг. Мөн Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулах, төсөвт тусгах, олон нийтийн оролцоог хангах, төсвийн мэдээллийг ил тод мэдээлэх эрх зүйн суурь болдог.

Сүүлийн жилүүдэд Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх үйл явц, хэрэгжилтэд хийсэн аудит, хяналт шинжилгээ, үнэлгээний дүнгээс үзэхэд төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулах, эрэмбэлэх ажиллагаа хангалттай ил тод бус, төсөл сонгосон үндэслэл, үнэлгээний мэдээлэл нийтэд нээлттэй бус, хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдаа сул, олон нийтийн оролцооны зохицуулалт бодитой хэрэгжихгүй байгаа зэрэг нийтлэг асуудал тогтоогдсон байна.

Үндэсний Аудитын газрын 2023-2025 оны аудитын тайлангуудад улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тодорхой хэсэг нь урьдчилсан үнэлгээний шаардлагыг бүрэн хангаагүй, төслийн бэлэн байдлын шалгуур дутуу боловч төсөвт тусгагдсан, анхны төсөвт өртөг болон хэрэгжих хугацаа удаа дараа өөрчлөгдсөн, олон жил дамжин хэрэгжиж буй барилга байгууламжийн тоо өндөр хэвээр байгааг дурдсан байна. Мөн төсвийн төсөл боловсруулах шатанд төсөл, арга хэмжээг ямар шалгуураар эрэмбэлж сонгосон талаарх мэдээлэл олон нийтэд нээлттэй бус, төсвийн хөрөнгө оруулалтын төслийн үнэлгээний үр дүн төсвийн төсөлд бүрэн тусдаггүй, төсвийн хэлэлцүүлэгт оролцсон иргэдийн санал шийдвэрт хэрхэн нөлөөлсөн талаарх эргэх холбоо хангалтгүй байгаа талаар судалгаа, үнэлгээний тайлангуудад тэмдэглэсээр иржээ. Нээлттэй төсвийн олон улсын түншлэлийн Нээлттэй төсвийн судалгааны үнэлгээнд Монгол Улсын төсвийн ил тод байдлын үзүүлэлт олон улсын дунджаас харьцангуй өндөр үнэлэгдсэн боловч олон нийтийн оролцооны үзүүлэлт хангалтгүй бөгөөд иргэд төсвийн төсөлд үр нөлөөтэй оролцох боломж хязгаарлагдмал гэж дүгнэсэн байдаг.

Иймд төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг нотолгоо, үнэлгээнд үндэслэн сонгон шалгаруулах, эрэмбэлэх, төсвийн мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, олон нийтийн оролцоог бодитой хангах, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан болно.

Нэг. Хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Хуулийн төслийг боловсруулах явцад Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн төслийн зардлын тооцоог боловсруулсан бөгөөд эдгээр бичиг баримтуудад Үндэсний аудитын газрын аудитын тайлан, дүгнэлтүүд, Сангийн яамны төсвийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тайлангууд, төсвийн ил тод байдал, олон нийтийн оролцооны талаарх олон улсын үнэлгээ, зөвлөмж, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын чиглэлээрх олон улсын сайн туршлагыг судалж шинжлэн холбогдох хэсгийг тусгасан болно.

Хоёр. Хуулийн төслийн хүрээнд тусгасан зарчмын шинэлэг зохицуулалт

2.1. Төсвийн хөрөнгө оруулалтын төслийг үнэлж, эрэмбэлэх эрх зүйн үндсийг бий болгоно.

Одоо мөрдөж байгаа хуульд төсөл, арга хэмжээг эрэмбэлэн төсөвт тусгах талаар тодорхой зохицуулалт хангалтгүй байгаа тул улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг оноогоор үнэлж, эрэмбэлсний үндсэн дээр төсөвт тусгах, үнэлж эрэмбэлээгүй төслийг төсөвт тусгахыг хориглох зохицуулалтыг шинээр тусгасан. Энэ нь төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг нотолгоо, шалгуур үзүүлэлтэд суурилах ач холбогдолтой юм.

2.2. Төсвийн хөрөнгө оруулалтын мэдээллийн ил тод байдлыг шинэ түвшинд хүргэх зохицуулалт тусгав.

Төсөл, арга хэмжээний үнэлгээ, эрэмбэ, төсөвт өртөг, санхүүжилт, хэрэгжилтийн мэдээллийг олон нийтэд цахимаар тогтмол мэдээлэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн. Мөн төсвийн төсөлд хавсаргах хөрөнгө оруулалтын мэдээллийн агуулгыг өргөжүүлж, төслийн код, байршил, хүчин чадал, нийт өртөг, үнэлгээний оноо, эрэмбэ, үндэслэл, тайлбар зэрэг мэдээллийг заавал тусгахаар тусгасан.

2.3. Олон нийтийн оролцоог бодитой болгоно.

Төсвийн хялбаршуулсан танилцуулгын агуулгыг хуульчилж, иргэдийн саналыг хүлээн авах, шийдвэрлэлтийн талаарх эргэх холбоог тайлагнах үүргийг шинээр тогтоосон. Мөн иргэдэд зориулсан төсвийн товч танилцуулгыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.

2.4. Хариуцлагын зохицуулалтыг тодорхой болгоно.

Төсөл, арга хэмжээг хуульд заасан үнэлгээ, эрэмбэлэлтийн шаардлага зөрчин төсөвт тусгасан, эсхүл олон нийтийн оролцоог хангах үүргээ хэрэгжүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцох зохицуулалтыг тодруулан тусгасан.

Гурав. Хуулийн төслийн үр нөлөө, ач холбогдол

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээгээр төсөлд тусгасан зохицуулалтууд нь Төсвийн тухай хуулийн зорилго, зарчимтай нийцэж байгаа бөгөөд Улсын төсвийн хөрөнгө оруулалтын сонгон шалгаруулалтын ил тод байдлыг нэмэгдүүлэх, хөгжлийн бодлогын баримт бичиг болон төсвийн төлөвлөлтийн уялдааг сайжруулах, төсвийн мэдээллийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, олон нийтийн оролцоог бодитой хангах, төсвийн сахилга, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх эерэг үр нөлөөтэй гэж дүгнэсэн. Зардлын тооцооны тайлангаар уг хуулийн төсөл хэрэгжсэнээр Улсын төсөвт шинээр нэмэлт зардал үүсэхгүй, төрийн байгууллагын бүтэц, орон тоог нэмэгдүүлэх шаардлага гарахгүй болно.

Дөрөв. Хуулийн төсөл батлагдсантай холбогдон авах арга хэмжээ

Хуулийн төсөл батлагдсаны дараа Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах журмыг батлах, шинэчлэх шаардлага үүснэ. Үүнд

- Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг үнэлэх, оноо өгөх, эрэмбэлэх аргачлал;
- Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үнэлгээ, эрэмбэ, хэрэгжилтийн мэдээллийг нийтлэх журам;
- Иргэдэд зориулсан төсвийн танилцуулга боловсруулах аргачлал, загвар;
- Олон нийтийн хэлэлцүүлгийн санал хүлээн авах, нэгтгэх, тайлагнах журам.

Хуулийн төсөл батлагдсантай холбогдуулан өөр хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах шаардлага үүсээгүй бөгөөд энэхүү хуулийн төслийн хамт өөр хуулийн төсөл өргөн мэдүүлээгүй болно.

---o0o---